

# УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН БОДЛОГО

## ҮНДЭСЛЭЛ

Хүлэмжийн хий болон газар цэвэрлэхээс үүдэлтэй уур амьсгалын өөрчлөлт нь өнөө үеийн хамгийн тулгамдсан асуудал билээ. Энэ нь дэлхийн хэмжээнд шийдэх ёстой асуудал бөгөөд гариг дэлхийдээ бид амьд үлдэхэд хамгийн гол сорилт болоод байна. Дэлхийн уур амьсгал өмнө байгаагүй хурдаар өөрчлөгдөж байгаа ба энэ нь дулаарал, далайн төвшин нэмэгдэх, далай хүчилжих, байгалийн гамшгийн давтамж ойртох, үер ус, ган зуд болох зэргээр илэрч байна. Уур амьсгалд бий болсон нөхцөл байдал нь дайн дажин, өвчин өлсгөлөн, цөлжилт, хүчээр нүүлгэн шилжүүлэх, амьтан ургамал устах зэрэг сөрөг үр дагавар дагуулна. Уур амьсгалын өөрчлөлтийг бий болгож буй бохирдуулагч бодисуудын ялгаралтыг 2030 он гэхэд хоёр дахин, 2050 он гэхэд тэглэх ёстой. Уур амьсгалыг хэвийн болгох болон бодис ялгаруулдаггүй технологийн төлөө бүгд хамтран улс төрийн төвшинд хэрэгжих боломжтой, тэнцвэртэй шийдлүүдэд хүрэх шаардлагатай.

## АЛСЫН ХАРАА

Уур амьсгалын гамшгаас урьдчилан сэргийлэхийн тулд бид уур амьсгалын тэгш байдлыг хангах, үр дүнтэй бууруулах арга хэмжээ, хувирах боломжтой стратегиудыг хэрэгжүүлэх, нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулах, шатах ашигт малтмал ашигладаггүй ирээдүйг бий болгох ёстой.

## ЗОРИЛТ

Дэлхийн Уур амьсгалд үүсээд буй нөхцөл байдлыг дэлхийн төвшний арга хэмжээгээр даван гарах ба яаралтай алхамуудыг хийх шаардлагатай. Иймд Гринсийн зорилтууд нь дараах болно:

- Уур амьсгалын өөрчлөлтөнд нөлөөлөх бохирдуулагч бодис буюу хүний бий болгосон Уур амьсгалын өөрчлөлтөд хамаатай гол хийнүүд болох нүүрстөрөгчийн давхар исэл, метан, азотын исэл, озон, хлорфтор нүүрсустөрөгч ба гидрофтор нүүрсустөрөгч зэрэг нийлэг хийг бууруулах
- 2030 он гэхэд дэлхийн ялгаралыг хамгийн багадаа хоёр дахин бууруулж 2050 он гэхэд тэглэх буюу сөрөг хэмжээнд хүргэх
- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын Суурь Конвенц, Киотогийн Протокол, Парисын хэлэлцээрт нүүрстөрөгчийн ялгаралт болон модгүйжэлт зэргийг бууруулж дэлхийн температур өсөлтийг 1.5<sup>o</sup> C-иас бага төвшинд хязгаарлах гэж заасан дэлхийн төвшний арга хэмжээг хэрэгжүүлэх
- Уур амьсгалын өөрчлөлтөнд түүхэндээ болон одоо хамгийн их хувь нэмэр оруулж буй аж үйлдвэржсэн баян орнуудыг танин тодорхойлж дэлхийн хэмжээнд ялгаралтыг бууруулах, зохицуулах арга хэмжээний ачааг тэгш хуваан ялгаруулалтыг бууруулах олон талт гэрээ хэлэлцээр байгуулах
- Шатах ашигт малтмалын салбарын бүх дэмжлэгийг зогсоох. Шатах ашигт малтмал олборлолт, шатах ашигт малтмалд суурилсан цахилгаан үйлдвэрлэл, шатах ашигт малтмалын хэрэглээг ялгаруулалт бууруулах төлөвлөгөөний дагуу зохион байгуулалттайгаар бууруулж төгсгөх

- Хяналтын интервенц хийн нүүрстөрөгчид үр дүнтэй өндөр үнэ тавьж шатах ашигт малтмалыг сэргээгдэх эрчим хүчээр солих төлөвлөгөө гаргах зэрэг төрөл бүрийн механизмаар дамжуулан нүүрстөрөгчийн ялгаруулдаггүй эдийн засагт шилжих
- Санхүүжилт сайтай, цогц, нэгдсэн, нотолгоонд суурилсан, бүх салбаруудад хүлэмжийн ялгаралтыг бууруулах зохистой зорилтууд заан өгч тайлагнахыг шаардсан ялгаруулалт бууруулах төлөвлөгөөгөөр дамжуулан 2050 он хүртэл улсын хэмжээний ялгаруулалтын хязгаарыг жил бүр мөрдөн хэрэгжүүлэх
- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд ноцтой өртсөн орнуудад зориулсан дасан зохицох арга хэмжээг дэмжиж санхүүжүүлэх үр дүнтэй дэлхийн механизмийг бий болгох
- Аж үйлдвэрийн түүчээлсэн уур амьсгалын бууруулалтын зорилтууд, цэвэр эрчим хүчрүү шилжих шилжилтийг дэмжих
- Ой мод, усархаг газар болон бусад ач холбогдол бүхий ялгарал гаргадаггүй экосистемүүд зэрэг нүүрстөрөгч шингээдэг газруудыг хадгалж хамгаалах, нөхөн сэргээх ажлыг дэмжих

## **АЖЛЫН ХӨТӨЛБӨР**

Гринс нь олон улсын гэрээ хэлэлцээрийг бататган улс орон, ард иргэдийг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохисч бууруулахад тус болох төлөвлөгөөнүүдээр дамжуулан дэлхийн болон улсын ялгаруулалтыг хурдтай бууруулахыг зорьж ажиллана.

### **Ирээдүйн уур амьсгал**

- Дэлхийн дулаарлыг 1.50C-ээс доош байлгахад чиглэсэн Уур Амьсгалын Өөрчлөлтийн Хууль гаргах
- Хүлэмжийн хийн ялгаруулалтыг хязгаарлах шаардлагыг багтаасан төсөв батлах
- Ой мод, хүлэрт тал, далайн эрэг, усархаг газар зэрэг нүүрстөрөгч шингээдэг газруудыг хамгаалж сэргээх гэрээ хэлэлцээрийг олон улсад байгуулахыг уриалах
- Ялгаруулалтгүй эдийн засаг, нийгэмрүү шударгаар шилжих
- Шинэлэг технологиудын судалгаа хөгжүүлэлт, төслүүдийг санхүүжүүлэх
- Уур амьсгалтай холбоотой алдагдал хохиролд нөхөн төлбөр төлөхийг уриалах
- НҮБ-ийн Тогтвортой Хөгжлийн Зорилгууд буюу ялангуяа ТХ313-ийг дэмжин уур амьсгалын өөрчлөлт, түүний нөлөөллүүдтэй тэмцэх яаралтай арга хэмжээнүүдийг авах
- Орон нутагт ажиллан нүүрстөрөгч ялгаруулдаггүй нийгмийг бүтээх
- Иргэд болон гол өмч, дэд бүтцийн аюулгүй байдлыг хангахуйц бууруулах, зохицох хөтөлбөрүүдийг бий болгох
- Бүх төрийн байгууллага болон бизнесүүдийг тус тусын дасан зохицох төлөвлөгөөг гарган уур амьсгалын нөхцөл байдлыг бууруулахад тус тусдаа хувь нэмэр оруулах зорилтуудыг (ХНОЗ) тодорхойлохыг уриалах
- Нүүрстөрөгч ихтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ буюу ялангуяа эрчим хүч үйлдвэрлэл, аж үйлдвэр, тээвэр, хөдөө аж ахуй, ойн аж ахуй болон бусад газар ашиглалтын (ХААОААГА) эрэлтийг бууруулах
- Гэр бүл төлөвлөлт, хаягдалгүй эдийн засаг, зохистой хэрэглээ, нүүрстөрөгч багатай бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцруу шилжих шилжилтрүү уриалах

- Нүүрстөрөгчийн татвар (нүүрстөрөгчид суурилсан түлш шатаахад ноогдуулах татвар) баталж шатах ашигт малтмалын хэрэглээг хязгаарлан нийгэмд өөрчлөлт бий болгох
- Намын хуваагдлыг арилгах үүднээс уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх нам хамтарсан дотоод хэрэг эрхлэх газрыг байгуулах
- Аж үйлдвэрт ялгаруулалтыг бууруулах хууль гарган мөрдүүлж хязгаараас хэтрэхэд торгууль ноогдуулах
- Хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах урт хугацааны болон түр зорилтуудыг бий болгох
- Бууруулах арга хэмжээ бүхий шударга шилжилтийн шууд нөлөөлөлд өртсөн иргэдийг дэмжиж ажиллах
- НҮБ-ын бүрэлдэхүүн байгууллагын дэмжлэгийн доорх олон улсын уур амьсгалын бүх гэрээ хэлэлцээрүүдийг дэмжих
- Улсын хэмжээнд хаягдал тэглэх бодлого гаргах
- Уур амьсгалын өөрчлөлтийн мэдлэгийг нэмэгдүүлж тус бүрдээ ялгаруулалтыг бууруулах стратегийг уриалан дэмжих олон нийтийн боловсрол мэдээллийн кампанит ажлуудыг явуулах

### Эрчим хүч, тээвэр

- Бүх салбар, ялангуяа орон сууц (тохиргоо засвар хийх санхүүжилт олгох), аж үйлдвэр, тээвэрт эрчим хүчийг үр ашигтай байлгахад хөрөнгө оруулалт хийх
- Машин, цахилгаан бараа, тоног төхөөрөмжинд эрчим хүчний үр ашигтай байдлын стандартыг тавьж аажмаар нэмэгдүүлэх
- Шатаадаг болон цөмийн эрчим хүчийг салхи, нар, далай, давалгаа, жижиг оврын усан, газрын дулаан болон бусад сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдээр даруй солих цэвэр эрчим хүч бүрдүүлэх стандарт батлах
- Нийгмийг бохирдуулдаггүй, сэргээгдэх эрчим хүчийн эх үүсвэр ашиглахаар хяналт зохицуулалт хийх
- Шинэ шугам хоолой, нүүрс, тос, хийн өрөмдлөг, олборлолт, далайн олборлолтыг хориглох
- Одоо байгаа ураны уурхай, цөмийн цахилгаан станцуудыг ашиглалтаас гаргаж шинээр байгуулахыг хориглох
- Одоо байгаа тос, хийн олборлолтуудыг аажмаар бууруулах
- Битумын үйлдвэрлэл нь хүлэмжийн хийд их хэмжээгээр хувь нэмэр оруулдаг тул 2030-35 гэхэд зогсоосон байх
- Гидравлик цуулалтын үйл ажиллагаа нь газрын доорх усны чанарт нөлөөлж метан хий гарган газар хөдлөлт үүсгэдэг тул хориглох
- Эрчим хүчний хувьд үр ашигтай тохиргоо засварыг орон байр, үйлчилгээний газар, албан газруудад хийх өргөн хүрээний ажлыг өрнүүлэх
- 2030 гэхэд дотоод шаталтат хөдөлгүүртэй автомашины худалдааг хориглох
- Цахилгаан машиныг хямд төсөр болгож цахилгаан машин цэнэглэх цэгүүдийг авто зогсоолд тавих зэргээр нэмэгдүүлэх
- Ялгаруулалтгүй тээврийг дэмжихийн тулд улсын хэмжээний дугуй, алхалтын замын дэд бүтцэд санхүүжилт гаргах

- Ногоон тээвэрлэлтийн хөтөлбөрийг хөгжүүлэх
- Тээвэрлэлт, төмөр замын маршрутыг хүн ам ихтэй газраас холдуулахад санхүүжилт өгч төмөр замын аюулгүй байдлын дүрэм журмыг чангатган аюултай материалуудыг төмөр замаар тээвэрлэхэд иргэдийг хамгаалах
- Хүмүүсийн амьдрах орчин, аж үйлдвэрийн чадамжийг нэмэгдүүлэн орон нутгийн сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлж дэлгэрүүлэх
- Нүүрсээр ажилладаг цахилгаан станц, хийн уурхай, тос олборлолтыг хориглон одоо байгаа нүүрс, хийгээр ажилладаг цахилгаан станц, уурхайнуудын өргөжилтийг хориглох
- Хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулдаг нь нотлогдсон биологийн төрөл зүйлийн олон янз байдал, хүнсний баталгаатай байдалд аюул учруулдаггүй тогтвортой түлш судлан хөгжүүлж амьдрал дээр хэрэгжүүлэх ажлыг хийх
- Аж үйлдвэр, үйлдвэрлэлд нүүрстөрөгч ялгаруулдаггүй технологийг хөгжүүлж амьдрал дээр хэрэгжүүлэх ажлыг хийх, ялангуяа аж үйлдвэрийн үйл явцад шатах ашигт малтмалыг шууд ашиглах явдлыг өөрчлөх
- Үр ашигтай, зардал багатай нийтийн тээврийн тогтолцоог бий болгох

### **Хөдөө аж ахуй, ойн аж ахуй**

- Азотын бордоог тариа ногоонд хэрэглэхийн бууруулах, элэгдлийг бууруулж хөрсийг сэргээн нүүрстөрөгчийг хадгалалах, үйлдвэржсэн мал аж ахуйгаас хөндийрөх улсын стандарт хэрэгжүүлэх
- Үйлдвэржсэн хөдөө аж ахуйн системээс нөхөн сэргээх хөдөө аж ахуйруу шилжих шилжилтийг дэмжих
- Уугуул иргэд болон орон нутгийн мэдлэгт тулгуурлан урт хугацааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ойн гал түймрийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх
- Нүүрстөрөгчийн давхар ислийг агаар мандалд гаргалгүй фотосинтезээр шингээн авах хөдөө аж ахуй, ойн аж ахуй, газар ашиглалтын дэглэмүүдийг дэмжих
- Газар цэвэрлэх, байгалийн ой мод бэлтгэх болон бусад үйл ажиллагааг хориглон нүүрстөрөгч агаарт хадгалагдах болон замагт ой, далайн өвс ургамлын давхаргад заналхийлэх аюулыг бууруулах
- Органик тариалан, орон нутгийн хүнсний үйлдвэрлэл, түгээлтийг дэмжих
- Малыг хашиж өсгөх үйл ажиллагааг төгсгөн метан, азотын исэл болон бусад хүлэмжийн хийг бууруулах, махны хэрэглээг багасгахыг уриалах

### **Шатах ашигт малтмал**

- Метан, азотын исэл болон бусад хүлэмжийн хийг бууруулах, шаттдаг түлш, цөмийн эрчим хүчгүй ирээдүйн төлөөх ажлын хөтөлбөр боловсруулах
- Шатах ашигт малтмал, цөмийн эрчим хүч, биомасс, хаягдал шатаалт, био түлшний тэтгэлгийг зогсоох
- Уур амьсгалын өөрчлөлтөнд хувь нэмэр бага оруулдаг орнуудын хувьд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход санхүүжилт олгох олон улсын механизмийг бий болгох

### **Судалгаа хөгжүүлэлт**

- Далайн болон агаарын тээврээс ялгарах хүлэмжийн хийг их хэмжээгээр бууруулах механизмийг судлах, хөгжүүлэх, амьдралд хэрэгжүүлэх ажлыг хийх
- Хөдөө аж ахуйгаас ялгарах хүлэмжийн хийг их хэмжээгээр бууруулах механизмийг судлах, хөгжүүлэх, амьдралд хэрэгжүүлэх ажлыг хийж нүүрстөрөгч ихээр ялгаруулдаг хүнсний үйлдвэрлэлээс хөндийрөхийг уриалах

#### **Ашигласан материал:**

<https://www.un.org/en/sections/issues-depth/climate-change/>

<https://www.globalgreens.org/policies/climate-protection-plan>

<https://gp.org/cgi-bin/vote/prodetail?pid=522>

<https://www.greenparty.ca/en/platform/climate-emergency>

<https://policy.greenparty.org.uk/cc.html>

<https://europeangreens.eu/positions/climate-energy>

<https://indiagreensparty.org/policies/energy-and-climate-change/>

<https://greens.org.au/policies/climate-change-and-energy>

[https://www.greens.org.nz/climate\\_change\\_policy](https://www.greens.org.nz/climate_change_policy)

<https://sustainabledevelopment.un.org/sdg13>